

ӨРХИЙН САНХҮҮГИЙН ИНДЕКС, ТҮҮНИЙ ШИЛЖИХ МАГАДЛАЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ (Орхон аймгийн жишээн дээр)

Т.Ууганбаяр*, Э.Жавхлан**, М.Сайхнаа***

Хураангуй: Дэлхийн улс орнууд урт хугацааны тогтвортой эдийн засагт хүрэхийн тулд аливаа улсын өрхийн амьжиргааны түвшин, ядуурлын түвшин, хүний хөгжлийн индекс, аз жаргалын индекс, өрхийн санхүүгийн байдал зэрэг нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцож төр засгийн зүгээс бодлогын баримт бичиг боловсруулан, үндэсний хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн. Энэ хүрээнд олон улсын судлаачид 1965 оноос хойш өрхийн санхүүгийн тогтвортой байдал, сайн сайхан байдал, эмзэг байдлыг индекс зэрэг олон аргачлалыг хөгжүүлэн судалгаа шинжилгээний ажил хийж ирсэн. Үүний дотроос 2011 оноос Их Британи улсын Бристолын Их Сургуулиас өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх Household financial wellness index аргачлалыг хөгжүүлэн, Өмнөд африкийн жишээн дээр тасралтгүй 10 гаран жил судалгаа хийж, зөвлөмж боловсруулсан байна. Бид Орхон аймгийн жишээн дээр өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг индексийн аргаар тодорхойлон, индекс шилжих магадлалыг ложит загвараар үнэллээ. Судалгааны үр дүнгээс харвал Орхон аймгийн өрхүүдийн 3.5% нь санхүүгийн нөхцөл байдал сайн, 50.75% нь санхүүгийн байдал тогтвортой, 40.5% нь санхүүгийн байдал тогтворгүй, 5.25% нь хямарсан бөгөөд эдгээр өрхүүдийн санхүүгийн байдал тогтворгүй болох эрсдэл өндөртэй, хямарсан өрхүүд сайжрах магадлал бага байна. Тиймээс цаашдаа өрхүүдийн санхүүгийн байдлыг тогтвортой, найдвартай болгох замаар эдийн засгийн урт хугацааны өсөлтийг хангахын тулд төр засгийн зүгээс бодлогын баримт бичиг боловсруулах, богино, урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь бидний судалгааны үр дүнгээс харагдлаа.

Түлхүүр үгс: *Микро индекс, макро индекс, хямарсан, тогтворгүй, ажилгүйдэл, дотоодын нийт бүтээгдэхүүн, Жини коэффициент*

Calculating probabilities of changes in the index of household financial condition

Abstract: In order for the world countries to achieve a long-term stable and reliable economy, the state of the country develops policy documents and implements national programs by considering social and economic indicators such as the standard of household living, the poverty level, the human development index, the happiness index, and the financial status of the household. In this framework, international researchers have been conducting research works since 1965, developing many methods such as household financial stability, well-being and vulnerability index. The University of Bristol of Great Britain has developed the household financial wellness index method to assess the financial sustainability of households in 2011, and has continuously conducted research and developed relevant recommendations on the example of households of South Africa for 10 years. Here on the example of households of the Orkhon province, the financial sustainability of the households was determined using the index method, and the probability of the index movement was evaluated using the logit model. According to the survey results, a total of 3.5% of households of Orkhon province have a good financial situation, 50.75% have a sustainable financial situation, 40.5% have an unstable financial situation, and 5.25% have a financial crisis. According to our survey results, it is necessary for the state to develop policy documents and implement short-term and long-term programs in order to ensure long-term economic growth by making the financial situation of households sustainable and reliable in the future.

Keywords: *Micro index, macro index, distressed, unstable, unemployment, Gross domestic product, Gini coefficient*

* Эрдэнэт Цогцолбор Дээд Сургууль, (E-mail): uuganbayar.t@erdenetis.edu.mn

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): e.javkhlan@num.edu.mn

*** МУИС, Ховд аймаг дахь салбар сургууль (E-mail): msaikhanaa11@gmail.com

Удиртгал

Дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшнийг нэг хүнд ногдох орлогоор хэмжиж, өөр хооронд нь харьцуулж ирсэн. Энэ нь орлогын ялгаатай байдлыг бий болгох, ядуурлын гүнзгийрэлт нэмэгдэх, байгалийн нөөц баялаг хомсдох, баян хоосны ялгааг нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгодог учир 1979 онд Артур Луйс, Теодер Шульц нар хөгжлийн эдийн засгийг үндэслэх болсон. Энэ онол нь дэлхийн хүн амын 70%-ийн материалаг амьдралыг дээшлүүлэхэд чиглэгдэг. Уг онолоор тухайн улсын эдийн засгийн хөгжлийн түвшнийг эдийн засгийн өсөлт болон өрх, хувь хүний амьдралын чанарын өөрчлөлтөөр хэмждэг. Хөгжлийн үйл явцад эдийн засгийн өсөлтийг(нэг хүнд ногдох орлого) бодвол чанарын хэмжигдэхүүн чухал үүрэгтэй гэж үздэг учир эрдэмтэд өрхийн амьдралын материалаг байдал, амьжиргааны түвшнийг илэрхийлэх илүү сайн үзүүлэлтийг эрэлхийлсээр байна. Өөрөөр хэлбэл, тухайн улсын хөгжлийн түвшнийг нэг хүнд ногдох орлогоос гадна хүн бүрд ногдох хоол хүнс хүрэлцээтэй эсэх, хүн бүрийн аюулгүй байдал, цэвэр ундны усаар хангагдаж чадаж байгаа эсэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чаддаг эсэх, боловсролын түвшин, дундаж наслалт, амьдралын баталгаа зэргийг нэг үзүүлэлтээр илэрхийлж чадах хэмжүүрийг хайсаар байгаа юм. Эдгээр үзүүлэлт нь тухайн өрхийн санхүүгийн байдал ямар байгаагаас шууд хамаардаг. Санхүүгийн салбар өргөжин тэлж, санхүүгийн шинэ төрлийн бүтээгдэхүүн бий болох тусам өрхөд амьжиргаагаа дээшлүүлэх олон шинэ боломжууд бий болохоос гадна санхүүгийн олон төрлийн шинэ эрсдэл бий болж байна. Санхүүгийн зах зээл глобалчлагдаж байгаа энэ үед дан ганц нэг хүнд ногдох орлого бус өрхийн санхүүгийн байдалд үндэслэн эдийн засгийн хөгжүүлэх нь зүйтэй юм. Тухайлбал, өрхийн санхүүгийн байдал сайжрахад тэдгээрийн худалдан авах чадвар нэмэгдэж нийт эрэлтийг өсгөнө. Ингэснээр үйлдвэрлэл нэмэгдэж, ажлын байр бий болж, ажилгүйдэл буурна. Энэ нь урт хугацаандаа эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох үндэс суурь болдог.

Тиймээс сүүлийн жилүүдэд Их Британи, Өмнөд Африкийн улсуудад өрхийн санхүүгийн байдал буюу санхүүгийн бодит байдлыг сайн сайхан байдлын индексээр тооцох аргачлалыг (Cantril, 1965) анх хөгжүүлж, өрхүүд санхүүгийн байдалдаа хэр сэтгэл ханамжтай байгааг (Strumpel, 1976) өрхийн тэргүүний орлого, хадгаламжтай холбоотой ойлголтыг нэмж өргөжүүлсэн юм. Үүний дараа (Garman & Porter, Testing a Conceptual Model of Financial Well-Being, 1993) нар өрхийн санхүүгийн сайн сайхан байдлын тухай ойлголт, үзэл баримтлал, үнэлгээний аргачлалыг боловсруулан туршиж байжээ. 2011 оноос хойш Их Британи улсын Бристолын их сургуулиас боловсруулсан HFWI (Household

financial wellness index) аргачлалыг ашиглан өрхийн санхүүгийн байдлыг өрхийн биет капитал, хүмүүн капитал, капиталжсан хөрөнгө, байгалийн капитал, нийгмийн капитал зэрэгт үндэслэн тооцоолж байсан бол 2016 оноос эхлэн өрхийн санхүүгийн байдал нь макро эдийн засгаас хэрхэн хамаарч байгааг тодорхойлон өрхийн санхүүгийн байдлыг үнэлэх аргачлалыг сайжруулжээ. Ингэснээр төрийн бодлого иргэдэд хүртээмжтэй, бодит үр дүнгээ өгдөг байна.

Монгол улс өрхийн төсөв, санхүүгийн талаар 2012-2015 онд “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр⁴”-ийг батлан хэрэгжүүлж, үүний хүрээнд өрхийн амьжиргаа, амьдралын чанарыг “орлогыг орлуулан тооцох арга”-аар өрхийн амьжиргааны түвшнийг тогтоож байсан бол 2015 оноос “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр⁵” боловсруулан, өрхийн санхүүгийн байдлыг бэхжүүлж, санхүүгийн үр ашгийг боломжит хамгийн өндөр түвшинд хүргэх замаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангахыг зорьж байна.

Иймд судалгааны ажлын зорилго нь өрхийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлж, санхүүгийн байдал шилжих магадлалыг тодорхойлох.

Үүний тул дараах зорилтуудыг тавилаа. Үүнд:

- Өрхийн нөхцөл байдлыг санхүүгийн индексээр тодорхойлох
- Өрхийн санхүүгийн байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээ хийж шилжих магадлалыг тодорхойлох

Өрхийн санхүүгийн байдал, үр ашгийн үнэлгээг хийснээр өрхүүдийн амьдралын чанар, санхүүгийн байдлыг шууд дүгнэх боломжтой юм. Энэхүү сэдвийг судалснаар дараах ач холбогдолтой.

Судалгааны хамрах хүрээ, тоон өгөгдөл

Судалгааны эх олонлог нь Орхон аймгийн нийт өрх байна. Эх олонлогоос пропорциональ давхаргад түүврийн аргыг ашиглан 95%-ийн магадлалын түвшинд, алдааны хязгаарыг 5% байна гэж үзэн дараах томъёогоор түүврийн хэмжээг тооцно.

⁴ нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасны дагуу ҮСХ-ны дарга, Нийгмийн хамгааллын сайд хамтран 2010 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 58/36 дугаар тушаалаар баталсан

⁵ Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр дэмжин улмаар 10 дугаар сарын 7-ны өдрийн хамтарсан тушаалаар баталсан үндэсний хэмжээний иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр юм.

$$\rho = \frac{Z^2 \cdot r(1-r) \cdot Pop}{(Pop-1) \cdot E^2 + Z^2 \cdot r(1-r)}$$

Z -95%-ийн итгэх магадлалын түвшин

Pop – Эх олонлог буюу нийт хүн амын тоо

r - тогтмол утга

e – алдааны хязгаар


Хүснэгт 1. Түүвэрлэлтийн хэмжээ

Баг, хороо	Баг, хорооны код	Өрхийн тоо	Нийт өрхөд эзлэх хувь	Судалгаанд хамрагдах өрхийн тоо
Баян-Өндөр	26101	28045	96.5%	386
1-р баг, Зэст	2610151	1517	5%	21
2-р баг, Оюут	2610153	1589	6%	22
3-р баг, Уурхайчин	2610155	1623	6%	22
4-р баг, Хүрэнбулаг	2610157	1570	6%	22
5-р баг, Уртбулаг	2610159	1427	5%	20
6-р баг, Согоот	2610161	1618	6%	22
7-р баг, Дэнж	2610163	1620	6%	22
8-р баг, Бүрэнбүст	2610165	1219	4%	17
9-р баг, Шанд	2610167	713	3%	10
10-р баг, Наран	2610169	979	3%	13
11-р баг, Цагаанчулуут	2610171	2012	7%	28
12-р баг, Булаг	2610173	771	3%	11
13-р баг, Баянцагаан	2610175	1433	5%	20
14-р баг, Говил	2610177	876	3%	12
15-р баг, Рашаант	2610179	1114	4%	15
16-р баг, Малчин	2610181	176	1%	2
17-р баг, Эрдэнэ	2610183	2036	7%	28
18-р баг, Баянбулаг	2610185	844	3%	12
19-р баг, Их залуу	2610187	1144	4%	16
20-р баг, Даваат	2610189	1119	4%	15
21-р баг, Уртын гол	2610191	867	3%	12
22-р баг, Яргуйт	2610193	1778	6%	24
Жаргалант	26104	1029	3.5%	14
1-р баг, Улаантолгой	2610451	308	30%	4
2-р баг, Жаргалант	2610453	385	37%	5
3-р баг, Дулаан-Уул	2610455	336	33%	5

Судалгааны арга зүй

Өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг Household financial wellness index (HFWI) аргыг ашиглан тодорхойлсон. (Hayes & Evans, 2016) Уг аргачлал нь макро болон микро индексийг тооцоолж, тэдгээрийн нийлбэрээр өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлдог.

Зураг 1. Өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг тооцоолох индексийн аргын бүрэлдэхүүн хэсэг



Өрхийн санхүүгийн индексийн утга хэд байгаагаас хамааран тухайн өрхийн санхүүгийн байдлыг тодорхойлно. Санхүүгийн байдлыг ерөнхийд нь хоёр хуваана. (Univesrcity of Bristol, Univesrcity of South Africa, 2015) Үүнд:

- Санхүүгийн хувьд ямар ч асуудалгүй буюу санхүүгийн байдал нь сайн
- Санхүүгийн хувьд ямар нэгэн асуудалтай байгаа буюу санхүүгийн байдалд нь анхаарал хандуулах шаардлагатай.

Санхүүгийн хувьд ямар нэгэн асуудалтай өрхийг дотор нь гурав ангилна. (Univesrcity of Bristol, Univesrcity of South Africa, 2016) Үүнд:

- Санхүүгийн хувьд боломжийн өрх буюу санхүүгийн индексийн утга нь 60-80 хүртэл,
- Санхүүгийн хувьд тогтворгүй байдалтай байгаа өрх буюу санхүүгийн индексийн утга нь 30-60 хүртэл,
- Санхүүгийн хувьд хямралд орсон өрх буюу санхүүгийн индексийн утга

нь 0-30 хүртэл гэж тус тус ангилна.

Өрхийн санхүүгийн индексийн утга болон харгалзах оноо, ангиллыг дараах зурагт дүрслэн үзүүлэв.

Зураг 2. Өрхийн санхүүгийн тогтвортой байдал, түүний ангилал



Санхүүгийн байдал нь сайн



Санхүүгийн байдал тогтвортой



Санхүүгийн байдал нь тогтворгүй болсон



Санхүүгийн байдал хямарсан

Орхон аймгийн өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг тооцоолсон индексийн үр дүнг харьцуулалт, задлан шинжлэх, дүн шинжилгээ хийх зэрэг уламжлалт аргуудыг ашиглан үнэлэлт, дүгнэлт өгсөн. Мөн өрхийн санхүүгийн тогтвортой байдал шилжих магадлалыг ложит загвараар үнэлсэн.

Сэдвийн судлагдсан байдал

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд өрхийн санхүү, төсөв зохиох аргачлалын талаар ном сурах бичиг, гарын авлагууд хэвлэгдэж байгаа боловч судлаачдын судалгаа, шинжилгээний бүтээлүүд хангалтгүй байна. Олон улсад өрхийн санхүү, түүнийг индексийг тооцох, өрхийн санхүүгийн эмзэг байдлыг

үнэлэх зэрэг олон судалгаа хийгдсэн байдаг. Үүнээс, АНУ, Австрали улсуудын үндэсний хэмжээний тоон мэдээ, Европын төв банкнаас Европын улсуудад хийсэн судалгаа, Бристолын их сургуулиас Өмнөд Африкт хийсэн судалгааны сүүлийн хэдэн жилийн тайлангуудыг голчлон авч үзлээ.

Монголбанкны Судалгаа, статистикийн газрын судалгааны хэлтсээс “Нийгэм-эдийн засаг, өрхийн амьжиргааны түүвэр судалгаа”

Монголбанкны Судалгаа, статистикийн газраас Монгол улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, банк санхүүгийн байгууллагын хөгжлийн талаар 2016 оны 4 дүгээр сард олон нийтийн дунд 10 дахь жилдээ хийжээ. Уг судалгаандаа өрхийн амьжиргааны өнөөгийн байдлыг судлан үзэхийн тулд Улаанбаатар хотын бүх дүүрэг, 21 аймгийг хамруулан санамсаргүй түүврийн аргаар 4767 иргэнээс асуулгын аргаар судалгаа авч боловсруулжээ. Уг түүвэр судалгаагаар өрхийн орлого, зарлага, орлогын хүрэлцээ, өрхийн амьжиргааны талаар дэлгэрэнгүй судалжээ. Өрхийн орлогын хүрэлцээ нь өрхүүдийн орлого болон зарлагаас шууд хамаарах боловч микро түвшинд өрхийн санхүүгийн төлөвлөлт болон зөв шийдвэр гаргалт, санхүүгийн боловсрол, өрийн менежмент, зан төлөвийн өөрчлөлт гэх мэт зүйлсээс хамаарах бол макро түвшинд эдийн засгийн нөхцөл байдал, ажилгүйдэл, инфляц, төсвийн болон мөнгөний бодлогоос хамаарч байдгийг уг судалгааны ажлаас харагдаж байна. Нийгэм эдийн засгийн түүвэр судалгаанаас дараах үр дүнгүүд гарчээ. Үүнд:

- Улсын хэмжээнд судалгаанд оролцогчдын 49% нь өрхийн амьжиргаа хивэндээ гэсэн бол 38% нь буурсан гэж хариулсан. Иргэдийн бодит орлого өмнөх үеүдээс буурч, чиглэлийн индекс урьд өмнө нь байгаагүй бага утгад хүрсэн нь эдийн засгийн өсөлт саарсан, бизнесийн үйл ажиллагаа хумигдаж ажилгүйдэл нэмэгдсэн, иргэдийн бодит цалин дорвитой нэмэгдээгүй зэрэг нь нөлөөлсөн гэж дүгнэжээ.
- Хувийн болон төрийн байгууллагад ажилладаг тогтмол цалин, орлоготой иргэдийн өрхийн амьжиргаа бага зэрэг муудсан гэж байсан бол ажилгүй, цагийн ажил эрхэлдэг, тэтгэвэр байдаг иргэд өрхийн амьжиргааг илүү их муудсан байсан бол ажил эрхэлж буй салбараар нь авч үзвэл үйлчилгээ, барилга, худалдааны салбарт ажил эрхэлдэг иргэд илүү муудсан гэж хариулсан байгаа бол аялал жуулчлал, хөдөө аж ахуй, банк санхүүгийн салбарынхны амьжиргааны түвшин харьцангуй бага буурсан байна.
- Судалгаанд хамрагдсан иргэдийн 12% нь орлого өссөн, 46% нь хивэндээ, 42% нь муудсан гэж хариулсан. Үүнийг газар зүйн

байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хамгийн их буурсан, Дорноговь, Сүхбаатар, Архангай аймагт орлого өссөн үзүүлэлттэй гарчээ.

- ☑ Улсын хэмжээнд санал асуулгад оролцсон иргэдийн 6% нь орлого амьжиргаанд хангалттай хүрэлцдэг, 36% нь боломжийн гэсэн бол иргэдийн талаас илүү хувь буюу 58% нь хүрэлцдэггүй гэсэн хариултыг өгчээ. Улаанбаатар хотын иргэдийн хувьд орлого хүрэлцдэггүй гэсэн хариулт хөдөө орон нутагтай харьцуулахад бага зэрэг өндөр байгаа нь Улаанбаатар хотын иргэдийн хэрэглээ хөдөө орон нутагтай харьцуулахад өндөр, түүнчлэн ипотекийн зээлд хамрагдагсдын дийлэнх нь Улаанбаатар хотын иргэд байгаатай холбоотой гэж үзжээ.
- ☑ Орлогын хүрэлцээг аймаг тус бүрээр авч үзвэл Төв, Булган, Баянхонгор аймгуудын иргэдийн хувьд орлого хүрэлцээ хамгийн муу гэж хариулсан бол Увс, Дорноговь, Архангай, Орхон болон Говьсүмбэр аймгуудын иргэд орлогын хүрэлцээндээ бага зэрэг муу гэсэн үнэлгээг өгчээ.

Судалгааны дээрх үр дүнгүүдэд үндэслэн өрхийн амьжиргааг сайжруулахын тулд нэн тэргүүнд ажлын байрыг нэмэгдүүлэх, цалин, тэтгэврийг өсгөх, хэрэглээний барааны үнийн өсөлтийг бага түвшинд байлгах болон эдийн засгийн тогтвортой орчин бий болгох арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй гэж үзсэн байна.

Судлаачид дээрх судалгаанд дараах гол гол дүгнэлтийг хийжээ. Үүнд:

- ❖ Эдийн засгийн өсөлт тэр дундаа барилга, худалдаа, үйлчилгээний салбаруудын идэвхжил суларч, иргэдийн бодит орлого төдийлөн өсөөгүйн зэрэгцээ ажилгүйдэл нэмэгдсэн нь өрхийн амьжиргаа доошлоход нөлөөлж, улмаар иргэдийн дунд ядуурал нэмэгдсэн гэх хандлагыг өсгөсөн байна.
- ❖ Судалгаанд оролцсон иргэдийн талаас илүү хувь нь мөнгөн хуримтлал байхгүй бөгөөд эдгээр иргэд орлогоос давсан зардлаа ихэвчлэн зээлээр тэр дундаа банкнаас хэрэглээний зээл авч санхүүжүүлдэг байна. Авсан зээлээ эргүүлэн төлөхөд зээлийн хүү өндөр, хугацаа богино байгаагаас гадна ажилгүйдэл нэмэгдэж байгаатай холбоотойгоор өрхийн аль нэг гишүүн ажилгүй болох эрсдэл өндөр байна.

Daniel Gray “Household Finances, Well-Being and Subjective Financial Situation: An Empirical Analysis of Household Survey Data”

Daniel Gray 2013 онд Gray “Household Finances, Well-Being and Subjective Financial Situation: An Empirical Analysis of Household Survey Data” судалгаандаа өрхийн санхүүгийн сайн сайхан байдлыг Австрали, Британи, Герман улсуудын

15424 өрхийн түүвэр судалгаанд үндэслэн Zero-Inflated Beta загвар, Fractional Logit загвар, Model Performance of the Univariate загваруудаар өрхийн төсөв, санхүүгийн сайн сайхан байдлын хамаарлыг судалжээ. Судалгаандаа өрхийн байдалд өрхийн эрсдэл даах чадвар, нийт хөрөнгө, нийт өр төлбөр, цэвэр баялаг, орлого, нас, боловсрол, гэрлэлт зэрэг 28 төрлийн үл хамааран хувьсагч авсан. Судалгаанд хамрагдсан иргэдийн дундаж нас 52, 37% нь эмэгтэй, 15% нь гэрлэж байгаагүй, 5% нь ажил эрхэлдэггүй, 14% нь эрүүл мэнд муу, эрсдэл даах чадвар 0.33 нэгж бол судалгаанаас дараах үр дүнгүүд гарчээ.

- ☑ Өрхийн санхүүгийн сайн сайхан байдалд тогтмол нөлөөний загвараар эрсдэл даах чадвар эерэг, орлого эерэг, гэр бүл салалт сөрөг, тэтгэвэр сөрөг нөлөө үзүүлдэг бол бусад хувьсагчид нөлөөлдөггүй байна.
- ☑ Пробит загварын үнэлгээгээр дээрх хувьсагчдаас гадна нас, гэр бүлтэй эсэх, ажиллах хүч, ажилгүйдлийн түвшин гэсэн хувьсагчид өрхийн санхүүгийн сайн сайхан байдалд нөлөөлдөг гэж гарчээ.

Үнэлгээг хийхдээ өрхийн санхүүгийн байдал ямар байхаас шалтгаалан 4 ангилалд хийсэн ба ангилал тус бүрийн үр дүн өөр гарсан. Энэ нь өрхийн санхүүгийн байдал ямар байхаас шалтгаалан нөлөөлж буй хүчин зүйлс өөр байгаа тул засгийн газар, эрх баригчдын зүгээс өрхийн санхүүгийн байдлыг дээшлүүлэх олон шийдэлт бодлого хэрэгжүүлэхгүй бол зарим өрхийн санхүүгийн байдалд эерэг нөлөө гарахгүй байх эрсдэлтэй хэмээн дүгнэжээ.

Тиймээс өрхийн санхүүгийн түвшнийг тогтоосны дараа тухайн өрх санхүүгийн байдал аль ангилалд байгаагаас шалтгаалан түүнд тохирсон арга хэмжээ, бодлого боловсруулах нь зүйтэй хэмээжээ.

“Өрхийн санхүүгийн сайн сайхан байдлын индекс”-ийн тайлан, 2011, 2012, 2013, 2014, 2015, 2016, 2017, 2018, 2019, 2020, 2021 он

Их Британи улсын Бристоллын их сургуулийн хувь хүний санхүүгийн судалгааны төвөөс өрхийн санхүүгийн сайн сайхан байдлын индексийг 2011 оноос хойш судалж, хөгжүүлэн ирсэн. Уг аргачлалын дагуу Өмнөд африк улсын жишээ дээр сүүлийн 7 жил судалгаа хийж, судалгааны тайланг олон нийтэд мэдээлж байна. Үүнээс гадна онлайн үйлчилгээгээр дамжуулан иргэдийн санхүүгийн байдлыг тодорхойлох төлбөртэй үйлчилгээг үзүүлж байна. Жил бүрийн судалгааны тайлан дээр өрхийн санхүүгийн байдлыг HFWI индексээр тооцож, Санхүүгийн байдал хүндэрсэн буюу хямарсан, санхүүгийн байдал тогтворгүй, Санхүүгийн байдал тогтвортой, Санхүүгийн байдал сайн гэсэн 4 ангилалд авч үзэн эдгээр өрхүүдийн санхүүгийн байдалд макро болон микро хүчин зүйлс хэрхэн яаж нөлөөлж байгааг тайлбарласан байдаг. Тухайлбал 2011

оны тайланд судалгаанд хамрагдсан иргэдийн 4.8% нь санхүүгийн байдал хямарсан, 48.5% нь санхүүгийн байдал тогтворгүй, насны бүлгээр нь авч үзвэл 17 наснаас 59 нас хүртэл иргэдийн санхүүгийн байдал сайжирдаг бол 60 наснаас эргээд буурдаг гэсэн үр дүнг гаргажээ. Иргэдийн санхүүгийн байдал муу байгаагийн шалтгаан нь хүүгийн түвшний өсөлт, инфляцын өсөлтөөс үүдэн бодит орлогын бууралт байсан гэж дүгнэжээ.

2017 оны судалгааны тайланд 2011 оноос 2016 он хүртэл өрхүүдийн санхүүгийн байдал хэрхэн өөрчлөгдсөнийг зургаар харуулсан бөгөөд 2011 онд санхүүгийн байдал хүндэрсэн буюу хямарсан өрхүүд судалгаанд хамрагдсан өрхүүдийн 4.8% байсан бол 2016 онд 2.3% болж буурсан, мөн бусад ангиллууд хэрхэн яаж өөрчлөгдсөнийг харуулжээ. Мөн 2015 оноос 2016 онд өрхүүдийн нийгмийн капитал, биет капитал, хүмүүн капитал, байгалийн капитал, капиталжсан хөрөнгө хэрхэн яаж өөрчлөгдсөнийг өрхүүд өрхийн санхүүгээ удирдах технологи буюу санхүүгийн боловсрол, өрийн менежмент, зан төлөвийн өөрчлөлт, өрхийн төсөв, санхүүгийн төлөвлөгөө ба эрсдэлийн төлөвлөгөө сайжирсан гэж дүгнэжээ. Уг тайландаа өрхийн санхүүгийн удирдлага, санхүүгийн сайн сайхан байдал нь өрхийн хүмүүн капитал, нийгмийн капитал гэсэн 2 төрлийн орцыг өрхийн төсөв, санхүүгийн төлөвлөгөө, эрсдэлийн төлөвлөгөө, санхүүгийн зан төлөвийн өөрчлөлт, санхүүгийн боловсрол, өрийн удирдлага гэх мэт үйл ажиллагаа буюу технологиос хамааран өрхийн биет капитал, капиталжсан хөрөнгө, байгалийн капитал гэсэн гарцуудыг бий болгох ба уг гарцын нөлөө нь өрхийн санхүүгийн сайн сайхан байдал гэж үзсэн байна. Судалгааны үр дүнгээс харахад санхүүгийн байдал сайн өрхүүдийн орцыг гарц болгох технологи нь өндөр байна. Тиймээс өрхүүд орцыг гарц болгох технологийг 100% ашиглаж чадах юм бол санхүүгийн үр ашиг өндөр байх буюу үүнийг дагаад өрхийн санхүүгийн байдлыг дээшлэх боломжтой гэж дүгнэжээ.

ӨРХИЙН САНХҮҮГИЙН ТОГВОРТОЙ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Судалгааны найдвартай байдал


Судалгааны найдвартай байдлыг шалгадаг статистик арга зүй нь Кронбах альфа коэффициент байдаг. Энэ нь $0 \leq x \leq 1$ хооронд утгаа авах ба $0.7 \leq x$ байх нь ач холбогдолтой буюу судалгааны асуултуудын найдвартай байдлыг илэрхийлдэг. Мөн энэхүү коэффициентоор хэмжээс нь оновчтой эсэхийг тодорхойлж болдог. Бидний судалгааны үр дүнгээр энэхүү коэффициент 0.92

гарснаас харвал түүвэр судалгааны тоон өгөгдөл статистикийн хувьд найдвартай байгааг илтгэж байна.

Судалгаанд оролцогчийн шинж байдал


Орхон аймгийн өрхийн санхүүгийн байдлыг үнэлэхдээ Баян-Өндөр сумын 386 өрх, жаргалант сумын 14 өрхөөс түүвэр судалгаа авсан. Түүвэр судалгааг пропорциональ, давхаргат санамсаргүй түүврийн аргаар авсан болно. Судалгаанд оролцогчийн нас, хүйс, сарын дундаж орлого, боловсролын түвшин зэрэг хүн ам зүй, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийн ерөнхий төлөв байдлыг энэ хэсэгт авч үзэх болно.

Зураг 3. Судалгаанд оролцогчийн нас, хүйс



Судалгаанд оролцогчийн 83% нь эмэгтэй, 17% нь эрэгтэй бол насны хувьд 10% нь 30 хүртэл настай, 21% нь 30-39 настай, 25% нь 40-49 настай, 22% нь 50-59 настай, 25% нь 60-аас дээштэй настай байна. Судалгаанд оролцогчдын хувьд хүйсийн ялгаатай байдал их байгаа нь судалгааны үр дүнд сөрөг нөлөө үзүүлэхгүй.


Зураг 4. Судалгаанд оролцогчийн ажил эрхлэлт ба боловсролын түвшин



Судалгаанд оролцогчийн 21% нь төсөвт байгууллага, 27% нь төрийн болон орон нутгийн өмчид үйлдвэрийн газар, 24% нь хувийн хэвшилд, 14% нь хувиараа бизнес эрхэлж, 14% нь ашгийн бус байгууллагад ажиллаж байгаа бол эдгээрийн 55% нь бүрэн дунд, 25% нь бакалавр, 8% нь боловсролгүй, 6% нь техник, мэргэжлийн 4% нь магистр, доктор зэрэгтэй байна.


Судалгаанд хамрагдсан иргэдийн 74% нь байнгын ажилтай, 8% нь цагийн ажилтай, 11% нь тохиолдлын буюу хааяа ажил эрхлэлдэг, 7% нь сайн дураараа ажилладаг байна. Байнгын ажилтай иргэдийн 26.5% нь 800,000 төгрөгөөс 1.5 сая төгрөгийн орлоготой бол 22.7% нь 800,000 төгрөгөөс бага, 25.2% нь 1.5 сая төгрөгөөс их орлоготой байна. Цагийн болон хааяа ажил эрхлэлдэг иргэдийн дийлэнх нь 1.5 сая төгрөгөөс бага орлоготой байна.

Зураг 5. Судалгаанд оролцогчдын албан тушаал




Судалгаанд хамрагдсан иргэдийн 62% нь дунд буюу түүнээс доош шатны албан тушаалтан байсан бол 38 нь гүйцэтгэх, эсвэл, удирдах албан тушаалтан байжээ.

Зураг 6. Ажилд орсон суваг



Судалгаанд хамрагдсан иргэдийн 42% нь ажил олгогч нарт анкет бөглөсөн бол 28% нь найз нөхөд хамаатнаасаа тусламж гуйсан, 19% нь хэвлэл мэдээллийн зарын дагуу ажилд оржээ. Тэдгээрийн 12% нь сүүлийн 12 сарын хугацаанд үндсэн ажлаасаа гадна түр хугацаагаар давхар ажил эрхэлж, нэмэлт орлого олсон байна.

Зураг 7. Санхүүгийн боловсрол ба өрхийн орлого, зардал



Санхүүгийн огт мэдлэггүй өрхийн 19% нь орлого, зардлаа, 17% нь ирээдүйн зорилгодоо хүрэхийн тулд санхүүгийн төлөвлөгөө гаргадаг байна. Харин санхүүгийн боловсрол хангалттай сайн гэж хариулсан иргэдийн 60% орчим нь орлого, зардлаа төлөвлөж, ирээдүйн зорилгодоо хүрэхийн тулд санхүүгийн төлөвлөлт хийж байна.


Өрхийн санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ, түүний үр дүн

Өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх HFWI аргачлалаар энэхүү хэсэгт үнэллээ. Уг үнэлгээг хийхдээ Орхон аймгийн 400 өрхөөс түүвэр судалгаа авч үнэлгээний үр дүнг дараах байдлаар харуулсан. Үнэлгээг хийхдээ HFWI аргачлалын дагуу макро болон микро индекс тооцож түүний нийлбэрээр өрхийн санхүүгийн индекс тооцсон.

Өрхийн санхүүгийн макро индекс

Өрхийн санхүүгийн макро индексийг тооцохын тулд HFWI аргачлалын дагуу үнэллээ. Үүний тулд Орхон аймгийн сүүлийн 10 жилийн ажилгүйдлийн түвшин, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, жини итгэлцүүрийг үндэсний статистикийн хороо, статистик мэдээллийн сангаас авч ашиглалаа.

Зураг 8. Орхон аймгийн ажилгүйдлийн түвшин, сүүлийн 10 жилээр




Эх сурвалж: https://www2.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L04&type=tables

Орхон аймгийн ажилгүйдлийн түвшин сүүлийн 10 жилээр авч үзэхэд 2018 онд хамгийн бага утгадаа буюу 1.7%, 2015 онд хамгийн их утгадаа буюу 4.9%-д хүрч байжээ. Энэ тоо мэдээнээс үзэхэд ойрын таван жилийн хугацаанд ажилгүйдлийн түвшин 1.7 хувиас 4.9 хувь хүртэл хэлбэлзэнэ хэмээн таамаглал дэвшүүлж болно. 2016 онд Бристолын их сургуулийн хувь хүний судалгааны төвөөс гаргасан аргачлалын дагуу ажилгүйдлийн түвшний хамгийн бага утгад ажилгүйдлийн түвшинд өгөх хамгийн өндөр үнэлгээ (10 оноо), ажилгүйдлийн түвшний хамгийн их утгад ажилгүйдлийн түвшинд өгөх хамгийн бага үнэлгээг (0 оноо) өгөх замаар тайлант жилийн бодит ажилгүйдлийн түвшинд өгөх үнэлгээг тооцсон. Орхон аймгийн хувьд Макро индекс тооцоход шаардагдах ажилгүйдлийн түвшний дээд хязгаар 5.23% бол доод хязгаар 1.37%, 2022 оны жилийн эцсийн байдлаар ажилгүйдлийн түвшин 3.3% байгаа тул макро индекс тооцох ажилгүйдлийн түвшний үзүүлэлт нь дараах байдалтай байна.

$$АТХО = 10 - \left((3.3\% - 1.37\%) \cdot \frac{10}{(5.23\% - 1.37\%)} \right) = 5$$

Макро индекс тооцох ажилгүйдлийн түвшний үзүүлэлтийг 10 хүртэл оноогоор үнэлдэг бол Орхон аймгийн хувьд уг үзүүлэлт нь 5 оноо гарч байна.

Зураг 9. Хангайн бүсийн орлогын тэгш бус байдал(Жини итгэлцүүр)



https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1900_036V2&dundaj_select_all=0&dundajSingleSelect=_9&YearQ_select_all=1&YearQSingleSelect=&viewtype=table

Орлогын тэгш бус байдал нь аймаг, дүүргээр гардаггүй учир бүсээр сонгон авч Орхон аймгийг төлөөлүүлэн үзлээ. Хангайн бүсийн хувьд энэхүү итгэлцүүр нь 2013 онд хамгийн ихдээ буюу 0.353 хүрч байсан бол 2018 онд хамгийн бага буюу 0.307 хүрч байжээ.

2019 оны III улирлын байдлаар жини итгэлцүүр 0.32 тул жини итгэлцүүрт өгөх үнэлгээг тооцвол дараах байдалтай байна.


$$\text{ЖИӨҮ} = 10 - \left((0.34 - 0.274) \cdot \frac{10}{(0.386 - 0.274)} \right) = 9.41$$

Макро индекс тооцох жини коэффициентод харгалзах оноо нь хамгийн багадаа 0 бол хамгийн ихдээ 10 оноо байна. Хангайн бүсийн хувьд уг үзүүлэлтийн үнэлгээ нь 9.41 гарч байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнд өгөх үнэлгээ. Макро индекс тооцох нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний өөрчлөлтөд өгөх үнэлгээ нь ажилгүйдлийн түвшний үзүүлэлт болон жини итгэлцүүрийн үнэлгээнд өгөх аргачлалаас ялгаатай. ДНБ-ний өнгөрсөн үеийн тоон үзүүлэлтээс харахад нэг хүнд ногдох ДНБ нь урт хугацаандаа өсөх хандлагатай байсан. Тухайлбал, 2000 оноос 2003 онд дэлхийн улсуудын ДНБ-ны хэмжээ 2009 оны санхүүгийн хямралтай байсан үетэй харьцуулахад бага байсан боловч 2009 оны хямралын үед дэлхийн нийтээрээ 2003 онтой харьцуулахад материаллаг байдал муудсан байсан. Өөрөөр хэлбэл, 2009 оны санхүүгийн хямралын үед эдийн засгийн нөхцөл байдал 2003 онтой харьцуулахад доройтсон байсан боловч ДНБ-ний хэмжээ 2003 оныхоос их байсан. Нөгөө талаараа ДНБ өсөлтийн хэмжээ нь маш их байдаг учир дээд хязгаарыг тогтоох боломжгүй (Hayes & Evans, 2016).

Орхон аймгийн хувьд сүүлийн 10 жилд нэг хүнд ногдох ДНБ дараах байдлаар өөрчлөгдөж ирсэн байна.

Зураг 10. Орхон аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний өөрчлөлтийн хувь



https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0500_011V1&S0UM_select_all=0&S0UMSingleSelect=_0_261&YearY_select_all=1&YearYSingleSelect=&viewtype=table

Орхон аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний өөрчлөлтийг сүүлийн 6 жилээр аваад үзвэл 2020 онд 5.5%, 2021 онд 0.1%-иар буурсан бол бусад жилүүдэд өсөлттэй байжээ. 2022 онд нэг хүнд ногдох орлого 4.3%-ийн өсөлттэй гарсан нь цар тахлын дараа бизнесийн үйл ажиллагаа сэргэсэн, дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ өссөн зэрэгтэй холбоотой юм.

Орхон аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний өөрчлөлтөд өгөх оноог дараах томъёогоор тооцно.

$$\text{ДНБӨҮ} = (4.3\% - (-0.055\%)) \cdot \frac{10}{(5.66\% - (-0.055\%))} = 8.77$$

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4.3%-иар өссөн тул дээрх аргачлалаар 8.77 оноогоор үнэллээ. Орхон аймгийн ажилгүйдлийн түвшин, жини коэффициент, нэг хүнд ногдох орлогын өөрчлөлтийг ашиглан макро индекс тооцвол дараах байдалтай байна.


$$\text{Макро индекс} = 5 + 9.41 + 8.77 = 23.18$$

Орхон аймгийн макро индекс 30 онооноос 23.18 оноо буюу 77.3% үнэлэгдсэн. Орхон аймгийн өрхүүдийн санхүүгийн тогтвортой байдал нь эдийн засгийн нөхцөл байдлаас 30% нь хамаардаг. Орхон аймгийн хувьд макро индекс 23.18 гарсан нь өрхүүдийн санхүүгийн тогтвортой байдалд аймгийн эдийн засгийн үзүүлэлтүүд 6.72 хувиар сөрөө нөлөө үзүүлж байна.

Өрхийн санхүүгийн микро индекс


Өрхүүдийн санхүүгийн нөхцөл байдлыг тодорхойлох микро индексийг судалгаанд хамрагдсан иргэдээс HFWI аргачлалын дагуу 7 бүлгийн 29 асуултаар тодорхойлсон.

Зураг 11. Микро индекс тооцох үзүүлэлтүүд



Орхон аймгийн өрхүүдийн санхүүгийн ерөнхий байдал сайнгүй байна. Тэд санхүүгийн богино болон урт хугацааны төлөвлөлтгүй, хөрөнгө оруулалт, хадгаламж хийдэггүй, санхүүгийн зах зээл дэх оролцооны түвшин хангалттай биш байна. Хэдий тийм ч өрхүүд банкны зээл болон бусад өр төлбөрийг хугацаандаа төлдөг, хямралыг даван туулах чадвартай ажээ. Микро индекс 70 оноогоор үнэлэгдэх ёстойгоос Орхон аймгийн өрхүүдийн дундаж үзүүлэлтээр 40.64 оноогоор үнэлэгдсэн. Микро индекс тооцох үзүүлэлт тус бүрийн задаргааг хавсралтаар харуулав. Өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох макро болон микро индексийн нийлбэр нь судалгаанд хамрагдсан өрхүүдийн дундаж үзүүлэлтээр 63.18 буюу санхүүгийн байдал тогтвортой ангилалд байгаа бол ангилал тус бүрд эзлэх хувийн жинг тооцож үзвэл дараах байдалтай байна.

Зураг 12.Өрхийн санхүүгийн тогтвортой байдлын индекс



Судалгаанд хамрагдсан нийт 400 өрхийн мэдээлэлд үндэслэн өрхийн санхүүгийн индексийг тооцоход 5.25% нь санхүүгийн хямралд орсон буюу гаднын тусламж шаардлагатай, 40.5% нь санхүүгийн байдал тогтворгүй буюу санхүүгийн хямралд ороход бэлэн байгааг илтгэж байгаа бол 50.75% нь санхүүгийн хувьд тогтвортой түвшинд хүрсэн ч санхүүгийн буруу шийдвэр, орлогын тасалдалт нь санхүүгийн байдлыг тогтворгүй болгох эрсдэлтэй юм. Харин үлдсэн 3.5% нь одоогийн улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалд санхүүгийн байдал нь тааламжтай сайн байна.

ӨРХИЙН САНХҮҮГИЙН ИНДЕКС ШИЛЖИХ МАГАДЛАЛ

Бид өмнөх хэсэгт өрхийн санхүүгийн нөхцөл, байдлыг HFWI индексээр тооцоход, судалгаанд хамрагдсан нийт 400 өрхийн 5.25% нь санхүүгийн байдал муу буюу хямарсан, 40.5% нь санхүүгийн байдал тогтворгүй, 50.75% санхүүгийн байдал боломжийн түвшинд хүрсэн, 3.5% нь санхүүгийн байдал сайн гэсэн үр дүн гарсан. Тэгвэл энэ хэсэгт бид санхүүгийн индексэд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээг Ложит загвараар хийж ангилал шилжих магадлалыг тооцлоо. Ложит загвараар үнэлгээ хийхдээ HFWI индексийн үр дүнгийн 4 ангилалд 6 загвар үнэлсэн.

Хүснэгт №2. Ложит загварын үнэлгээ хийхэд ашиглагдсан хувьсагчид

	Индекс	хамааран хувьсагч	Үл хамааран хувьсагч	Хувьсагчдын тэмдэглэгээ
Загвар 1	0-30%	0	Сууцны өмчийн хэлбэр	K1
	30%-60%	1	Архаг хууч өвчтэй хүн байгаа эсэх	K2
Загвар 2	0-30%	0	Орлого, зардлаа төлөвлөдөг эсэх	K3
	60%-80%	1	Санхүүгийн төлөвлөлт хийдэг эсэх	K4
Загвар 3	0-30%	0	Санхүүгийн мэдлэг	K5
	80%-100%	1	Нас	K6
Загвар 4	30%-60%	0	Боловсрол	K7
	60%-80%	1	Ажил эрхлэлт	K8

Загвар 5	30%- 60%	0	Ажилладаг байгууллага	K9
	80%- 100%	1	Орлого	K10
Загвар 6	60%- 80%	0	Албан тушаал	K11
	80%- 100%	1	Давхар ажил эрхэлдэг эсэх Хуримтлал	K12 K13

Загвар 1: Санхүүгийн байдал 0-30% гарсан 21 өрхөд 0 үнэлгээ, 30%-60% гарсан 162 өрхөд 1 үнэлгээ өгөн нийт 183 өрхийн түүвэрт үндэслэн ложит загвараар үнэлгээ хийсэн.

Загвар 2: Санхүүгийн байдал 0-30% гарсан 21 өрхөд 0 үнэлгээ, 60%-80% гарсан 203 өрхөд 1 үнэлгээ өгөн нийт 224 өрхийн түүвэрт үндэслэн ложит загвараар үнэлгээ хийсэн.

Загвар 3: Санхүүгийн байдал 0-30% гарсан 21 өрхөд 0 үнэлгээ, 80%-100% гарсан 14 өрхөд 1 үнэлгээ өгөн нийт 35 өрхийн түүвэрт үндэслэн ложит загвараар үнэлгээ хийсэн.

Загвар 4: Санхүүгийн байдал 30%-60% гарсан 162 өрхөд 0 үнэлгээ, 60%-80% гарсан өрхөд 1 үнэлгээ өгөн нийт 454 өрхийн түүвэрт үндэслэн ложит загвараар үнэлгээ хийсэн.

Загвар 5: Санхүүгийн байдал 30%-60% гарсан 162 өрхөд 0 үнэлгээ, 80%-100% гарсан 203 өрхөд 1 үнэлгээ өгөн нийт 365 өрхийн түүвэрт үндэслэн ложит загвараар үнэлгээ хийсэн.


Загвар 6: Санхүүгийн байдал 60%-80% гарсан 203 өрхөд 0 үнэлгээ, 80%-100% гарсан 14 өрхөд 1 үнэлгээ өгөн нийт 217 өрхийн түүвэрт үндэслэн үнэлгээг Eviews9.0 программаар хийсэн.

Үнэлгээний үр дүнгээс харахад загварт хувьсагчдын нөлөөтэй эсэхийг z шинжүүр болон түүний магадлалын утгаар шинжихэд үл хамааран хувьсагчид нь өрхийн санхүүгийн байдлаас шалтгаалан зарим зарим загварт 1%, 5%, 10%-ийн итгэх түвшнээс бага гарч байхад зарим хувьсагчид загварт статистикийн хувьд найдваргүй үнэлэгджээ. Бүх загварт ижилхэн дараах хувьсагчид статистикийн хувьд найдвартай буюу өрхийн санхүүгийн индексэд нөлөөлдөг байна. Үүнд:

Загварын итгэлтэй байдал буюу ажиллах чадвар нь бүх загварын хувьд 90%-иас дээш үнэлэгдсэн ба хамгийн өндөр нь загварт 3-т 98.6% байсан бол загвар 5-ийн хувьд 91.76 хувьтай гарсан.

Загварын үнэлгээний үр дүнгээр санхүүгийн хувьд “хямарсан”, “тогтворгүй”, “боломжийн”, “сайн” өрхүүд ангилал шилжих магадлалыг тооход дараах үр дүн гарлаа.

Зураг 13. Өрхийн санхүүгийн байдал өөрчлөгдөх магадлал



Санхүүгийн байдал 0-30% буюу “хямарсан” өрхүүдийн санхүүгийн байдал нь “тогтворгүй” ангилалд шилжих магадлал 18.33%, “боломжийн” ангилалд шилжих магадлал нь 13.35%, “сайн” ангилалд шилжих магадлал нь 8.66% байгаагаас харвал одоогийн эдийн засгийн нөхцөлд уг өрхүүдийн санхүүгийн байдал сайжрах боломж муу байгааг харуулж байна. Харин санхүүгийн байдал “тогтворгүй” өрхүүд “боломжийн” ангилалд шилжих магадлал 34.16%, “сайн” ангилалд шилжих магадлал 40.36% бол санхүүгийн байдал “боломжийн” ангилалд байгаа өрхүүд “сайн” ангилалд шилжих магадлал 52.49% байна.

Дүгнэлт

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн хөгжил, техник, технологийн дэвшил даяарчлагдаж байгаа өнөө үед дэлхийн улсуудын санхүү, эдийн засаг бие биеэсээ хамааралтай болж, санхүүгийн төрөл бүрийн эрсдэлийг нэмэгдүүлж байгаа нь өрхүүд санхүүгийн шийдвэр гаргахад улам бэрхшээлтэй болж байна.

Тиймээс бид энэхүү судалгаагаар Орхон аймгийн өрхүүдийн санхүүгийн байдлыг HFWI индексээр тооцоход 5.25% нь санхүүгийн чадавхгүй буюу “хямарсан”, 40.5% нь санхүүгийн хувьд “тогтворгүй”, 50.75% нь санхүүгийн хувьд “боломжийн” түвшинд хүрсэн ч, санхүүгийн буруу шийдвэр, богино хугацааны орлогын тасалдалтаас шалтгаалан санхүүгийн байдал “тогтворгүй” болох эрсдэлтэй, 3.5% нь санхүүгийн байдал “сайн” гэсэн үр дүн гарлаа. Уг тооцооллын үр дүн Орхон аймгийн ядуурлын түвшинтэй нийцэж байгаа нь

өрхийн санхүүгийн байдлыг тооцож буй HFWI аргачлал өрхийн санхүүгийн байдлыг тооцоход тохиромжтой байгааг харуулж байна.

Өрхийн санхүүгийн байдал нь өрхийн тэргүүний боловсрол, албан тушаал, ажил эрхлэлт, сууцны нөхцөл, санхүүгийн мэдлэг, зээлд хамрагдсан эсэхээс шалтгаалж байна.

Өрхийн санхүүгийн индексийг бууруулахад Орхон аймгийн эдийн засгийн нөхцөл байдал 6.82% сөрөг нөлөө үзүүлдэг бол өрхийн санхүүгийн удирдлага хангалтгүй байгаа байдал нь дунджаар 12%-ийн сөрөг нөлөө үзүүлж байна.

Өрхийн санхүүгийн байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээг ложит загвараар 6 загвар болгон тус бүрд нь үнэлэхэд санхүүгийн чадавх 0-30% буюу “хямарсан” өрхүүдийн санхүүгийн байдал нь “тогтворгүй” ангилалд шилжих магадлал 18.33%, “боломжийн” ангилалд шилжих магадлал нь 13.35%, “сайн” ангилалд шилжих магадлал нь 8.66% байгаагаас харвал одоогийн эдийн засгийн нөхцөлд уг өрхүүдийн санхүүгийн байдал сайжрах боломж муу байгааг харуулж байна. Харин санхүүгийн байдал “тогтворгүй” өрхүүд “боломжийн” ангилалд шилжих магадлал 34.16%, “сайн” ангилалд шилжих магадлал 40.36% бол санхүүгийн байдал “боломжийн” ангилалд байгаа өрхүүд “сайн” ангилалд шилжих магадлал 52.49% байна.

Цаашдаа судалгааны ажлыг сайжруулахын тулд өрхийн санхүүгийн нөхцөл байдлыг санхүүгийн үзүүлэлтүүдэд үндэслэн харьцааны шинжилгээ хийх, санхүүгийн хувьд хэр хамгаалагдсан байгааг тодорхойлох, мөн санхүүгийн үзүүлэлт сайжрахад өрхийн санхүүгийн нөхцөл, байдал хэрхэн дээшлэх боломжтойг тодорхойлох шаардлагатай байна.

Ашигласан материал

Altman, E. (1968). Financial ratios, discriminant analysis and the prediction. *The Journal of Finance*, 589-609.

ArthaYantra. (2013). *7 Ratios which tell your current financial health*. Retrieved from [www.arthayantra.com: https://www.arthayantra.com/blogs/7-ratios-which-tell-your-current-financial-health/](http://www.arthayantra.com/blogs/7-ratios-which-tell-your-current-financial-health/)

Australia and New Zealand Banking Group. (2018). *A Survey of adults in New Zealand: Financial wellbeing*. Retrieved from <https://www.anz.com/: https://www.anz.com/resources/9/b/9b03e8e5-5e86-4d56-9e9a-019242b7862a/financial-wellbeing-nz18.pdf?MOD=AJPERES>

Australia, F. c. (2019). *Family court of Australia-Financial case*. Retrieved from <http://www.familycourt.gov.au/: http://www.familycourt.gov.au/wps/>

wcm/connect/80f59580-a0d0-403a-96b3-22c7a36c203a/Financial_statement_form_0313V3.pdf?MOD=AJPERES&CONVERT_TO=url&CACHEID=ROOTWORKSPACE-80f59580-a0d0-403a-96b3-22c7a36c203a-md.UUxF

- Barnes, M., & Hughes, A. (2002). A quantile regression analysis of the *Federal Reserve Bank of Boston*.
- Cantril, H. (1965). The pattern of human concerns. *New Brunswick, NJ: Rutgers University press*.
- Centre of social impact. (2017). *EXPLORING FINANCIAL WELLBEING*. Retrieved from <https://www.csi.edu.au/>: https://www.csi.edu.au/media/Exploring_Financial_Wellbeing_in_the_Australian_Context_Appendices.pdf
- Elizabeth , W. (2006). *All Your Worth: The Ultimate Lifetime Money Plan*.
- Garman, E., & Porter, N. (1993). *Testing a Conceptual Model of Financial Well-Being*. Retrieved from <http://citeseerx.ist.psu.edu>: <http://citeseerx.ist.psu.edu/viewdoc/download?doi=10.1.1.379.6832&rep=rep1&type=pdf>
- Garman, E., Porter, N., & Lytton, R. (1991). How to use financial ratios when advising clients. *Financial Counseling and Planning*, 3-23.
- Gombola, M., & Ketz, J. (1983). Financial ratio patterns in retail and. *Financial Management*, 45-56.
- GREEN, W. (1997). *Econometrics Analysis* (3rd edition ed.).
- Harness, J., Chatterjee, S., & Finke, M. (2008). Household financial ratios: A Review of literature. *Journal of personal finance*, 77-97. Retrieved from <https://www.researchgate.net/>: <https://www.researchgate.net/search.Search.html?type=researcher&query=household%20financial%20ratio>
- Hayes, d., & Evans, J. (2016, 1). *Momentum UK Household Financial Wellness Index 2016*. Retrieved from researchgate: https://www.researchgate.net/publication/318672509_Momentum_UK_Household_Financial_Wellness_Index_2016
- Hayes, D., Jamie, E., & Finney , A. (2016). *Household Financial Wellness Index*. Их Британи.
- Horrigan, J. (1966). The determination of long-term credit standing with. *Journal of Accounting Research*, 44-62.
- Joo, S. (2008). Handbook of Consumer Finance Research. In *Personal Financial Wellness* (p. 21).

- KishorKumar, B. (2019). *The 7 Most Important Personal Finance Ratios You Need To know!* Retrieved from Хувийн хүний санхүү: <https://www.relakhs.com/7-important-personal-finance-ratios/>
- Mason, J., & Griffith, R. (1988). New ratios for analyzing and interpreting. *Journal of the Institute of Certified*, 71-87.
- Meltzer, L. (2019, 8 2). *The cent of money*. Retrieved from <https://thecentsofmoney.com/>: <https://thecentsofmoney.com/eighteen-personal-finance-ratios-you-should-know/>
- Momentum, & UNISA. (2016). *Household Financial Wellness Index: 2016 full report*. South Africa.
- OECD. (2019). *Compare your country using the OECD dashboard of household statistics*. Retrieved from OECD.org: <https://www.oecd.org/sdd/na/household-dashboard.htm>
- OECD and G20 Presidency . (2012). *Advancing national strategies for financial education*. Вашингтон.
- Pinches, G. E., & Mingo, K. (1973). A multivariate analysis of industrial. *The Journal of Finance*, 1-18.
- University of Bristol, Personal finance research centre. (2011). *HOUSEHOLD FINANCIAL WELLNESS INDEX*.
- University of Bristol, Personal finance research centre. (2016). *Household Financial Wellness Index: Quantitative methodology*. Britain.
- Univesrcity of Bristol, Univesrcity of South Africa. (2011). *Household Financial Wellness Index: 2011 full report*. South Africa.
- Univesrcity of Bristol, Univesrcity of South Africa. (2012). *Household Financial Wellness Index: 2012 full report*. South Africa.
- Univesrcity of Bristol, Univesrcity of South Africa. (2013). *Household Financial Wellness Index: 2013 full report*. South Africa.
- Univesrcity of Bristol, Univesrcity of South Africa. (2014). *Household Financial Wellness Index: 2014 full report*. South Africa.
- Univesrcity of Bristol, Univesrcity of South Africa. (2015). *Household Financial Wellness Index: 2015 Full report*. South Africa.
- Univesrcity of Bristol, Univesrcity of South Africa. (2016). *Household Financial Wellness Index: 2016 full report*. South Africa.
- Базарсад, Я., & Банзрагч, М. (2014). *Эконометрикийн арга загварууд* (2 дахь хэвлэл ed.). Улаанбаатар.

- Банзрагч, М. (2017). *Эконометрикийн цндэс*. Улаанбаатар.
- Будням, С., & Банзрагч, М. (2016). *Эконометрик*. Улаанбаатар.
- Монгол улсын сангийн сайдын тушаал. (2017, 12 14). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from <https://www.legalinfo.mn/>: <https://www.legalinfo.mn/annex/details/8277?lawid=13210>
- Монголбанк. (2016). *Орон сууцны ипотекийн санхүүжилтын журам*. Улаанбаатар.
- Пүрэв, Б. (2002). *Үйлдвэрлэлийн үр ашгийн параметрт ба параметрт бус шинжилгээ*.
- Элдэв-Очир, Т.-О. (2017). *ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮР АШГИЙН ДЕТЕРМИНИСТИК БОЛОН СТОХАСТИК ШИНЖИЛГЭЭ (МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ САЛБАРЫН ЖИШЭЭН ДЭЭР)*. Улаанбаатар.
- Энх-Амгалан, Б. (2016). *Эконометрикийн шинжилгээнд EViews ашиглах нь*. Улаанбаатар.
- Энх-Амгалан, Б. (2018). *СТАТА 14 програмыг шинжилгээнд ашиглах нь*. Улаанбаатар.
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2006, 06 22). *Санхүүгийн түрээсийн тухай хууль*. Retrieved from <https://www.legalinfo.mn/>: <https://www.legalinfo.mn/law/details/447>

Хавсралт 1. Микро индекс тооцох бүрэлдэхүүн хэсгүүд

Өрхийн санхүүгийн тойм үзүүлэлт			Санхүүгийн богино хугацааны төлөвлөлт		
Үзүүлэлт	Өрхүүдийн дундаж оноо	Дээд оноо	Үзүүлэлт	Өрхүүдийн дундаж оноо	Дээд оноо
Ойрын 3 сарын хугацаанд санхүүгийн хувьд ямар нэгэн асуудал гарах эсэх	1.78	2.5	Танай өрх сарын зардлынхаа хэмжээг төлөвлөдөг үү?	1.63	3.33
Ойрын 12 сарын хугацаанд санхүүгийн хувьд ямар нэгэн асуудал гарах эсэх	1.66	2.5	Танай өрх сарынхаа зардлыг орлоготой уяж төлөвлөдөг үү?	1.74	3.33
Өрхийн сарын орлого өдөр дутмын хэрэглэндээ хүрдэг эсэх	1.39	2.5	Танай өрх өдөр бүрийн зардлаа нэг бүрчлэн хянадаг уу?	1.46	3.33
Өрхийн санхүүгийн байдалдаа хэр зэрэг сэтгэл хангалуун байдаг эсэх	1.31	2.5	Нийт оноо	4.84	10.00
Нийт оноо	6.14	10	Санхүүгийн урт хугацааны төлөвлөлт		
Санхүүгийн хүндрэл, өр төлбөрийн үзүүлэлт			Үзүүлэлт	Өрхүүдийн дундаж оноо	Дээд оноо

	Өрхүүдийн дундаж оноо	Дээд оноо
Зээлийн гэрээний үүргээ биелүүлж чадахгүй тохиолдол гарч байсан эсэх	3.07	3.33
Сүүлийн 12 сарын хугацаанд албан бус зээлдүүлэгчээс өндөр хүүтэй зээл авсан эсэх. Тухайлбал, Ломбард, хувь хүн	2.93	3.33
Сүүлийн 12 сарын хугацаанд төлбөр, торгууль, акт зэргийг төлж чадахгүй тохиолдол гарсан эсэх	3.00	3.33
Нийт оноо	8.99	10.00
Санхүүгийн зах зээл дэх оролцооны түвшин		
Үзүүлэлт	Өрхүүдийн дундаж оноо	Дээд оноо
Танай өрхийн гишүүд банкинд данстай юу?	2.17	2.5
Танай өрх эрүүл мэнд, боловсрол, аялал зэрэгт зориулан хуримтлал хийх зорилгоор банкинд хэд хэдэн днас нээж ашигладаг уу?	0.89	2.5
Ирээдүйд учрах эрсдэлээс хамгаалахын тулд дараах даатгалаас аль алинд нь дааттуулсан вэ? Дааттуулсан даатгалын бүтээгдэхүүн бүрийг сонгоно	0.60	2.5
Танай өрхийн аль нэг гишүүн брокерын компанид данстай юу?	0.73	2.5
Нийт оноо	4.39	10.00

Ирээдүйд учирч болзошгүй хүндрэлийг давах туулахад шаардлагатай хуримтлалтай эсэх	0.72	2.5
Зорилгоо биелүүлэхэд хуримтлуулал үүсгэх, удирдах арга замын талаар суралцдаг эсэх	1.08	2.5
Тэтгэвэрт гарсны дараа авах тэтгэврийн хэмжээ хангалттай байхаар тэтгэврийн төлөвлөгөөгөө боловсруулсан эсэх	0.90	2.5
Хэрэв танай өрхөд гэнэтийн их дүнтэй зардал гарвал зээл авахгүйгээр төлөх боломжтой эсэх	0.86	2.5
Нийт оноо	3.56	10.00
Хямарлын даван туулах чадвар		
Үзүүлэлт	Өрхүүдийн дундаж оноо	Дээд оноо
Сүүлийн 12 сарын хугацаанд санхүүгийн эх үүсвэрээс хамааран зардлыг танах, хэмнэх тохиолдол гарсан уу?	2.33	3.33
Сүүлийн 12 сарын хугацаандаа хэрэглээгээ орлогодоо нийцүүлэхийн тулд зардал танах, орлого нэмэгдүүлэх ямар нэгэн арга хэмжээ авсан уу?	2.75	3.33
Сүүлийн 12 сарын хугацаанд хоёроос дээш удаа ямар нэгэн хүндрэл давтагдсан уу?	1.78	3.33
Нийт оноо	6.87	10.00